



ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 06 сарын 20 өдөр

Дугаар А/241

Улаанбаатар хот

“Гадаадын иргэн, харьяатын газрын
төрийн тусгай албан хаагчид мэргэшлийн
зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг
олгох журам” батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.7, 8.4, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.18 дахь хэсэг, Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээ”, уг журмын 5.1, 5.2, 5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Гадаадын иргэн, харьяатын газрын төрийн тусгай албан хаагчид мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг олгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг нийт албан хаагчдад танилцуулж, мөрдөж ажиллахыг төв болон хилийн боомт, орон нутаг дахь газар, хэлтсийн дарга нарт, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, удирдлагын газар (И.Баатархүү)-т тус тус даалгасугай.

ДАРГА



Н.УУГАНБАЯР

GIHG Tushaal 2024 on

172400924

Гадаадын иргэн, харьяатын газрын даргын
2024 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн
1/24 дугаар тушаалын хавсралт

ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬАТЫН ГАЗРЫН ТӨРИЙН ТУСГАЙ
АЛБАН ХААГЧИД МЭРГЭШЛИЙН ЗЭРЭГ ТОГТООХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
ТҮҮНИЙГ ОЛГОХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1.Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.2.3, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.18, Засгийн газрын 2024 оны “Журам батлах тухай” 160 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Гадаадын иргэний асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын албан хаагчид албан ажлын онцгой нөхцөлийн, төрийн алба хаасан хугацааны, цолны, мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох журам, нэмэгдлийн хэмжээ”-г тус тус баримтална.

1.2.Гадаадын иргэн, харьяатын газар (цаашид “байгууллага” гэх)-ын төрийн тусгай албан хаагч (цаашид “албан хаагч” гэх)-д мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт, түүнийг олгохтой холбоотой харилцааг энэ журмаар зохицуулна.

Хоёр. Мэргэшлийн зэрэг тогтоох шалгуур үзүүлэлт

2.1.Мэргэшлийн III зэргийг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчид олгоно.

2.1.1.төрийн албанд 1-5 хүртэл жил ажилласан байх;

2.1.2.албан хаагчийн сүүлийн 1 удаагийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ 85-100 оноотой “маш сайн”, 70-85 хүртэлх оноо “хэвийн” үнэлгээтэй байх;

2.1.3.сүүлийн 1 жилийн хугацаанд сахилга, ёс зүйн шийтгэлгүй байх.

2.2.Мэргэшлийн II зэргийг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчид олгоно.

2.2.1. энэ журмын 2.1-д заасан мэргэшлийн зэрэг хүчинтэй байх;

2.2.2.төрийн албанд 5-10 хүртэл жил ажилласан байх;

2.2.3.албан хаагчийн сүүлийн 1 удаагийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ 85-100 оноотой “маш сайн”, 70-85 хүртэлх оноотой “хэвийн” үнэлгээтэй байх;

2.2.4.сүүлийн 1 жилийн хугацаанд сахилга, ёс зүйн шийтгэлгүй байх.

2.3.Мэргэшлийн I зэргийг дараах шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчид олгоно.

2.3.1.энэ журмын 2.2-т заасан мэргэшлийн зэрэг хүчинтэй байх;

2.3.2.төрийн албанд 10 ба түүнээс дээш жил ажилласан байх;

2.3.3.албан хаагчийн сүүлийн 1 удаагийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ 85-100 оноотой “маш сайн” үнэлгээтэй байх;

2.3.4.сүүлийн 1 жилийн хугацаанд сахилга, ёс зүйн шийтгэлгүй байх.

2.4.Албан хаагч хуульч эсхүл өмгөөлөгчийн гэрчилгээтэй, гадаад хэлний ахисан түвшний мэдлэгтэй бол ажилласан жилийг харгалзахгүй, бусад шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг үндэслэн мэргэшлийн III зэрэг олгож болно.

Гурав. Мэргэшлийн зэрэг олгох, хүчингүй болгох, сэргээх

3.1.Албан хаагчийн харьяалах зохион байгуулалтын нэгжийн дарга тухайн албан хаагчид мэргэшлийн зэрэг тогтоолгох тухай хүсэлтийг холбогдох баримт бичгийн хамт Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгжид жил бүрийн 06, 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор ирүүлнэ.

3.2.Захиргаа, удирдлагын асуудал хариуцсан нэгж шалгуур үзүүлэлт хангасан албан хаагчид мэргэшлийн зэрэг шинээр олгох, ахиулахтай холбоотой саналыг байгууллагын даргад илтгэх хуудсаар танилцуулж, тушаалаар баталгаажуулна.

3.3.Энэ журмын 2.1-д заасан шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчид мэргэшлийн зэргийг шат дараалан олгоно.

3.4.Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг байгууллагад төрийн жинхэнэ албан хаагчаар томилогдсон, энэ журмын 2.1-2.3-т заасан шалгуур үзүүлэлтийг хангасан албан хаагчид ажиллаж байгаа хугацаанд нь олгоно.

3.5.Сахилгын болон ёс зүйн шийтгэл авсан албан хаагчийн мэргэшлийн зэргийг тухай бүр хүчингүй болсонд тооцно.

3.6.Сахилгын болон ёс зүйн шийтгэлтэйд тооцогдох хугацаа дууссан албан хаагчийн эхний болон сүүлийн хагас жилийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшний үнэлгээ, бусад шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг харгалзан мэргэшлийн зэрэг, нэмэгдлийг үргэлжлүүлэн олгоно.

3.7.Албан хаагч төрийн албанаас түр чөлөөлөгдсөн, чөлөөлөгдсөн, халагдсан, нас барсан бол мэргэшлийн зэргийг хүчингүй болсонд тооцно.

Дөрөв. Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгох

4.1.Мэргэшлийн зэргийн нэмэгдлийг Засгийн газрын тогтоолоор баталсан дараах хувь, хэмжээгээр албан тушаалын үндсэн цалингаас тооцож, сар бүр олгоно.

4.1.1. I зэрэг бол 20 хувь;

4.1.2. II зэрэг бол 15 хувь;

4.1.3. III зэрэг бол 10 хувь.

4.2.Мэргэшлийн зэргийн нэмэгдэл олгоход шаардлагатай санхүүжилтийг байгууллагын төсөвт тусгаж санхүүжүүлнэ.